МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР**
Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@ama.gov.mn,
Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.10.15 № 01/1766
танай ______-ны №______-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Тендер түдгэлзүүлэх тухай

Танай газраас зарласан “Уурын зуухны тогоо худалдаж авах /Шинэ-Идэр сум/ гүйцэтгэгч сонгох” ХӨАХААГ/20240102188 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Бэсүжин констракшн” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус газарт тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад холбогдох шаардлагатай баримт бичгийг албан бичгээр болон цахим шуудангаар (Chantsaldulam@ama.gov.mn) 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА Б.БИЛГҮҮН

0000469